

I. Монголын эртний түүхийн асуудлууд

ХҮЙ НЭГДЛИЙН НИЙГМИЙН ТҮҮХИЙН ҮЕЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛД

Б.Ралгаа

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим.

Өгүүллийн товч утга: Энэ өгүүлэлд хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхийн нэг чухал үе болох Хүй нэгдлийн нийгмийн үргэлжилсэн хугацаа, нэр, ялангуяа үечлэлийн асуудал, түүний онцлогийн талаар эрт эдүгээгийн судлаачдын дэвшүүлсэн таамаглал, үзэл санааг нэгтгэн дүгнэж, өөрийн санал дүгнэлтийг гаргах зорилго тавьсан юм.

Түлхүүр үг: Хүй нэгдэл, нэр томъёо, цаг хугацаа, үечлэл, онцлог

Хүн төрөлхтний түүхэнд цаг хугацааны хувьд хамгийн урт үргэлжилсэн нийгэм нь сая гаруй жилийн түүхтэй анхны хүй нэгдлийн нийгэм юм. Түүний эхлэлийг нарийн тодорхой тогтоох нь хялбаргүй билээ. Учир нь сүүлийн үеийн судалгаагаар олдсон нэн эртний хүний өвөг дээдсийн олдвор-булшны үлдэгдлийг судлаачдын зарим хэсэг нь хүний өмнөх үеийнх нөгөө хэсэг нь хүнийх гэж янз бүрийн таамаглал дэвшүүлдэг төдийгүй олонхи судлаачдын санал нь тогтвортой бус байгаа юм. Тиймээс орчин үеийн зарим судлаачид нь нэн эртний хүн 1,5-1 сая жилийн өмнө үүссэн гэж үздэг бол зарим хэсэг нь 2,5-2 сая жилийн өмнө үүссэн гэж үздэг. Ингэж нэн эртний хүн /хэдий үед/ үүссэн тухай санал нилээд зөрөөтэй байдаг нь ч харин манай дэлхийн эх газруудад /тивүүдэд/ харилцан ялгаатайгаар сүүлийн 5000 жил хүртэлх хугацаанд хүй нэгдлийн нийгэм оршин тогтнож байсан гэсэн бараг нэгдмэл дүгнэлтэнд хүрсэн билээ. Ази Африкт анхны ангит нийгэм МЭӨ 4-3 мянган жилийн хооронд үүссэн бол, Европт МЭӨ 1000 жилд, Америкт МЭ 1000 жилд, дэлхийн бусад газруудад түүнээс ч сүүлд үүссэн гэж үзэж байгаа билээ¹

Түүнчлэн хүй нэгдлийн үеийн түүх гэж нэрлэх асуудалд ч янз бүрээр ханддаг. Зарчмын хувьд бичгийн түүхээс хүй нэгдлийн үеийн бичгийн бус түүхийг тусгаарладаг "түүхийн өмнөх" гэсэн нэр томъёог зарим эрдэмтэд оновчтой бус гэж үздэг бөгөөд хэрэв анхны хүн төрөлхтөн үнэхээр хүй нэгдлийн үед байсан бол сүүлд ялангуяа, овгийн нийгмийн эриний өмнөх эринд дуусах үед энэ байдлаасаа гарсан байх ёстой гэж үздэг.

Түүнээс гадна өрнөдийн зарим хэлэнд "хүй нэгдэл" гэдэг нэр томъёо нь "бүдүүлэг", "энгийн" гэсэнтэй ижил утгатай бөгөөд энэ нь ангит нийгмийн өмнөх үеийн шатыг туулаагүй ард түмэнд хамааруулан хэрэглэхэд зохимжтой бус. Гэвч түүний оронд "ангит нийгмийн өмнөх түүх", "бичгийн бус түүх", "ураг төрлийн байгууллын түүх", "соёл иргэншлийн өмнөх түүх", "түүхийн эхлэл", "нэн эртний соёл иргэншил" зэрэг нэр томъёонуудыг зарим судлаачид хэрэглэж ирсэнийг цаашид нягтлан үзэх шаардлагатай юм².

Учир нь эдгээр нэр томъёонууд нь оновчтой бус төдийгүй сөрөг тодорхойлолт агуулагдаж байдаг. Үүнээс үүдэн хүй нэгдлийн түүх нь хүн төрөлхтний түүхийн бүх үе шатанд анхдагч, түүхийн дараа дараагийн бусад үе шаттай харьцуулбал анхдагч учир хүй нэгдэл гэж нэрлэж ирсэн нь тун оновчтой харагдаж байдаг. Тиймээс ч ихэнх судлаачид үүнийг хүлээн зөвшөөрч өнөөдөр

¹ В.П.Алексеев. А.И.Першиц. История первобытного общества. М.1999. 5 тал

² А.Ж.Тойнби. Постигение истории. М.1991., Ю.В.Яковец. Соёл иргэншлийн түүх. УБ., 1999.

Всемирная история учебник. М.1997. В.П.Алексеев. А.И.Першиц. История первобытного общества. М.1999. Всемирная история "каменный век", в 24 томах том 1. М 1996. Вопросы истории №3. 1980., №8 1988. Монгол улсын түүх. УБ. 1999. Дэлхийн дахины түүх. I боть. УБ., 2002; Монгол улсын түүх УБ., 2003. I боть.

хүн төрөлхтний анхны нийгмийн байгууллыг **"Анхны хүй нэгдлийн нийгмийн байгуулал"** гэж нэрлэсээр ирсэн юм.

Түүхийн шинжлэх ухааны судалгаа болон танин мэдэхүйд түүний хөгжлийг үечлэх асуудал чухал байр суурь эзлэдэг билээ. Ялангуяа **түүхийг үечлэх нь** түүний үе тус бүрийн онцлог шинжүүдийг нээн гарган, мэдэх гэж байгаа зүйлийн мөн чанарт нэвтрэн орох боломжийг бүрдүүлж өгдөг билээ.

Ингэж үечлэхдээ анхаарах нэг чухал зарчмын асуудал бол үечлэх шалгуурыг зөв сонгон авах нь чухал юм. Уг шалгуур нь тухайн үзэгдэл үйл явцын дотоод мөн чанарыг илэрхийлсэн байх нь зүйтэй боловч, судалгааны болон танин мэдэхүйн тухайлсан зорилгоос шалтгаалж аль нэг талыг голлон барих нь олонтоо байдаг. Иймээс түүхийг үечилж байгаа үечлэл нь өөр өөр байх талтай байдаг.

Иймд хүй нэгдлийн нийгмийн түүхийн үечлэлийн асуудал нь өөрөө бүхэл бүтэн үе шатыг туулсан төдийгүй энэхүү түүхэн замналыг нарийн судлахгүйгээр түүхийг үечлэх талаар орчин үед тавьж байгаа шаардлагыг бүрэн цэгцтэй гаргах боломжгүй юм. Энэ нь археологи, антропологи, этнографи, гэр бүл, соёлын хөгжлийн үечлэлийн хувьд ч хүй нэгдлийн түүхэн үйл явцын үечлэлтэй шууд хамааралтай билээ.

Хүй нэгдлийн нийгмийн түүхийн үндсэн агуулга, хөгжлийн чиг хандлагыг судалж гаргахдаа түүний үечлэлийн талаар нэн эртнээс эхлэн өөр өөрийн санал дүгнэлтийг дэвшүүлсэн олон хувилбар гаргасныг үе үеийн судлаачид баяжуулан хөгжүүлсээр ирсэн юм. Энэхүү үе үеийн олон эрдэмтэн судлаачдаас хүй нэгдлийн нийгмийн түүхийн үечлэлийн талаар дэвшүүлсэн дүгнэлтээс тоймлон авч үзье.

Хүй нэгдлийн түүхийн үечлэлийг **эртний грекийн яруу найрагч Гесиод /МЭӨ VIII-VII зууны үе/** анх дэвшүүлж **бурхан, алт, мөнгө, зэс, төмрийн гэсэн таван үед** хуваасан бол Грекийн гүн ухаантан Пифагор /МЭӨ VI зуун/ хөгжлийн ороомог онолын үндсийг боловсруулах аливаа юмс үзэгдлийн хөгжил нь ороомог /дугуй/ хэлбэрээр явагддаг гэсэн дүгнэлтийг хийж эхлэл үүсэл, хөгжил дэвшил, уналт бууралт мөхөл гэж хуваажээ³.

Түүнчлэн эртний **Ромын гүн ухаантан Лукреций Кар /МЭӨ 99-55/**, "Юмс үзэгдлийн мөн чанарын тухай" зохиолдоо төмрийн ертөнц үүссэн тухай бичихдээ эртний хүмүүс эхлээд **яс, шүд, чулуугаар хөдөлмөрийн багаж зэвсэг хийж байгаад зэс төмрийг хэрэглэх болсон тухай дурьджээ**⁴.

XVIII зууны үед **Францын соён гэгээрүүлэгч Жана Антуана Кондорсе /1743-1794/** хүн төрөлхтний түүхийг, бие биенээ дагалдан ээлжлэн солигдож, эрхлэх аж ахуйгаар нь анчлах, загасчлах, мал аж ахуй, газар тариалан гэж хуваах саналыг анх дэвшүүлжээ⁵. Тэрчлэн германы эрдэмтэн **Вруно-Гильбранд /1812-1878/** эртний хүмүүсийн эрхлэх аж ахуйгаар нь **натурал аж ахуй, мөнгөн аж ахуй, зээлийн аж ахуй** гэж Хүй нэгдлийн нийгмийн түүхийг үечилсэн байдаг⁶. **Оросын эрдэмтэн Л.И.Мечников /1838-1888/**, усан тээврийн хөгжлийн төвшингөөр нь **голын үе /эртний соёл иргэншил/, газрын дундад тэнгисийн үе /дунд үе/, далайн үе /шинэ нэн шинэхэн/** гэж түүхийг үечлэх оролдлогыг хийсэн байдаг⁷.

Шотландын философич А.Фергюсон /1723-1818/, этнографийн материал эд зүйл дээр үндэслэн хүний соёлын хөгжлийн ерөнхий төрх байдлыг гаргаж, орчин үеийн ард түмэн өөртөө хүй нэгдлийн ул мөрийг ямар нэг хэмжээгээр хадгалж байдаг төдийгүй судлаачдын тодорхойлсон бүдүүлэг овог

³ Всемирная история. учебник М.1997. стр 14

⁴ Всемирная история. Камменный век. В 24 томах. Том 1. М 1996. стр 20

⁵ А.И.Першиц, А.Л.Монгайт, В.П.Алексеев. История первобытного общества. М. 1974. 14 тал

⁶ Всемирная история. учебник М.1997. стр 14

⁷ Всемирная история. учебник М.1997. стр 15

аймгийн байдлаар бид, элэнц хуланц өвөг дээдсээ тольдон харж байгаатай адил харж байгаа тул тэдний амьдрал нөхцөл байдлыг сэргээн босгож чадах юм гээд Хүй нэгдлийн нийгмийн түүхийг анх **зэрлэг, бүдүүлэг иргэншил гэж гурван үед хуваасан** байдаг. Тэрээр зэрлэг бүдүүлгийн үеийг, аччлах загасчлахаас-газар тариалан, мал аж ахуй эрхлэх, нөгөө иргэншлийн үеийг хувийн өмчийг хууль эрх зүйн баталгаатай болсоноор тус тус зааглан тодорхойлсон байна⁸. Ийнхүү Фергюсон, хүн төрөлхтний түүхийг нэгдмэл байдлыг хүлээн зөвшөөрч, түүний ерөнхий үечлэлийг гаргахдаа эртний хүмүүсийн аж ахуй эрхлэх байдал, тэдний үйл ажиллагаа, өмчийн хөгжлийн хэлбэр шинж төрхийг өөрийн дэвшүүлсэн онолдоо гүнзгий тусгажээ.

Хүй нэгдлийн нийгмийн түүхийн үечлэлийн талаар дээрх судлаачдын дэвшүүлсэн эдгээр дүгнэлтийн зэрэгцээ хүн төрөлхтний нэн эртний үеийн археологийн олдворыг түүх судлалын хүрээнд оруулснаар үечлэлийн **цаг хугацааг тогтоох асуудал** аяндаа гарч ирсэн юм.

XIX зууны үед **Данийн археологич К.Ю.Томсен /1778-1865/, И.Я.Ворсо /1821-1885/** нар балар эртний хүний дурсгалыг харуулсан эд өлгийн зүйл ялангуяа булшны зохион байгуулалтыг үндэслэн хүй нэгдлийн нийгмийн түүхийг **чулуу, хүрэл, төмөр зэвсгээр нь** ангилан үечилсэн нь өнөөдөр нилээд түгээмэл хэрэглэж байгаа юм⁹. Ер нь XIX зууны үед хүчтэй хөгжиж ирсэн хувьсахуй онол нь хүй нэгдлийн нийгмийн түүхийн үечлэл, археологийн шинжлэх ухааны хөгжилд ихээхэн нөлөө үзүүлжээ. Хувьсахуйн онолын нэрт төлөөлөгч **английн эрдэмтэн Ж.Леббок /1834-1913/** археологи, этнографийн баримт мэдээг ашиглан чулуун зэвсгийг дотор нь анх удаа **палеолит, неолитын үе** гэж хуваажээ¹⁰.

Одоо ч ач холбогдолоо алдаагүй байгаа палеолитын үечлэлийг бий болгосон **Францын археологич Г.Мортилье /1821-1898/** нь өөрийн судалгаандаа геологи, палеозоологи, антропологийн аргыг нэн тэргүүнээ хэрэглэж, хүний нийгмийн хөгжил нь технологийн хөгжлөөс шалтгаалж, түүний хөгжлийн үе шат нь геологийн шинж чанараар тодорхойлогддог гэсэн дүгнэлтийг хийсэн байдаг. Түүний дэвшүүлсэн үечлэлтэй нэлээд төсөөтэй үзлийг **Шведын нэрт археологич О.Монтелус /1843-1921/** баримталж, нэлээд тодорхой болгон **неолит, хүрэл төмрийн түрүү үе** гэж хуваасан байдаг¹¹.

Хүй нэгдлийн нийгмийн хөгжлийн үечлэлийн асуудалд **Америкийн нэрт угсаатан судлаач Л.Г.Морган /1818-1881/** "Эртний нийгэм" зэрэг олон бүтээл бичиж асар их хувь нэмэр оруулсан билээ. Тэрээр, анх удаа энэ асуудалд системчилсэн хандлагыг ашиглан XVIII зууны үед бараг нийтээрээ зөвшөөрсөн үечлэх болох **зэрлэг, бүдүүлэг, соёл иргэншлийн ангиллыг үйлдвэрлэх хүчний хөгжлийн төвшингийн шалгуурт үндэслэн, дээр дурьдсан эринүүдийг дотор нь доод, дунд, дээд гэж хуваасан билээ**. Өөрөөр хэлбэл, **зэрлэгийн доод төвшин нь нэн эртнээс хүний авиа үг яриа үүсэхээс эхэлдэг бол, дундах нь загас агнуур, гал хэрэглэж сурахаас, дээдэх нь нум сум хэрэглэхээс эхэлдэг гэжээ. Бүдүүлгийн доод шатанд ваарны үйлдвэрлэл хөгжсөөр, дунд шат нь газар тариалан, мал аж ахуй эрхлэх болсноор, дээд шатан нь төмөрлөгийн үйлдвэрлэл эрхлэхтэй холбоотойгоор ангилжээ**. Төмрийн хүдэр хайлах явдлаас эхлээд бичиг үсэг зохиогдон аман бүтээлийг тэмдэглэхэд түүнийг хэрэглэсний үр дүнд соёл иргэншилд аажмаар оржээ¹².

Г.Морганы энэхүү үечлэлийг Ф.Энгельс цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлж "Зэрлэг үе бол бэлэн бүтээгдэхүүнийг голчлон хэрэглэж байсан үе бөгөөд

⁸ А.И.Першиц, А.Л.Монгайт, В.П.Алексеев. История первобытного общества. М. 1974. 14-15 тал

⁹ История древнего мира. М 1979. 5 тал

¹⁰ А.И.Першиц, А.Л.Монгайт, Б.В.Монгайт, Б.П.Алексеев. История первобытного общества. М.1974. 14-15 дахь тал.

¹¹ Всемирная история. "Каменный век" в 24 томах. том I. 1996. 21 дэх тал.

¹² А.И.Першиц, А.Л.Монгайт, В.П.Алексеев. История первобытного общества. М. 1974. 8-р тал

хүний зохиомол аргаар бүтээсэн бүтээгдэхүүн нь гол төлөв бэлэн зүйл авч хэрэглэхэд туслах багаж зэвсэг болж байжээ. Бүдүүлэг үе бол мал аж ахуй, газар тариалан үүссэн үе, хүний ажиллагаагаар байгалийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх арга эзэмшсэн үе юм. Соёлжсон үе бол байгалийн бүтээгдэхүүнийг цаашид боловсруулж, жинхэнэ аж үйлдвэр урлагийг хөгжүүлсэн үе юм"¹³ гээд хүй нэгдлийн түүхийн зэрлэгийн үеийн доод шатанд тохирох онцлогийг "хүн сүргийн" үеийн түүх гэж тодорхойлсон юм.

Хүй нэгдлийн түүхийн үечлэлээс хамгийн ач холбогдолтой нь хөдөлмөрийн багаж зэвсэг бэлтгэх техник, материалын ялгаан дээр үндэслэсэн археологийн үечлэл юм. Өөрөөр хэлбэл, нэн эртний түүхийг чулуу, хүрэл, төмөр гэж хуваасан нь XIX зууны эцэс XX зууны эхэн үед шинжлэх ухааны үндсэн дээр, судлах болж, тэдгээрийг дотор нь эрин, үе шат болгон хуваасан байдаг нь үндсэн хэлбэршиж ирсэн юм.

Чулуун зэвсгийн зуун нь доод, дунд, дээд палеолитийг хамарсан эртний чулуун зэвсгийн үеэс эхэлдэг. Дараа нь дундад чулууны зуун мезолитийн шилжилтийн эрин үе залгадаг бөгөөд, түүнийг заримдаа "палеолитын дараах эпипалеолит, "эсвэл" неолитын өмнөх үе гэж ч нэрлэдэг. Түүгээр ч зогсохгүй зарим судлаачид, мезолитын үе гэж тусад нь ялгадаггүй юм.

Чулуун зэвсгийн эрины сүүлчийн эрин болох шинэ чулууны /неолит/ төгсгөлд зэсээр хийсэн анхны хөдөлмөрийн багаж гарч ирсэн төдийгүй түүнийг энеолит буюу калколитын онцгой үе гэж үздэг билээ¹⁴.

Археологийн үечлэл нь хүй нэгдлийн түүхийн үнэмлэхүй болон харьцангуй он тоолол, цаг хугацааны дарааллын хэлхээсийг гаргах өргөн боломжийг олгосон билээ. Үнэмлэхүй он тоолол, цаг хугацааг тогтооход байгалийн шинжлэх ухааны төрөл бүрийн аргууд тухайлбал: радиокарбон ба калий-аргоны изотопийн арга /радио идэвх элементүүдийн задралын хугацаагаар/, геохронологийн /туузан шаврын жилийн цагиргаар/, дендрохронологийн, модны жилийн жилийн цагирагаар/ зэрэг бусад аргуудыг хэрэглэдэг. Эдгээр нь их бага ямар нэгэн алдаатай боловч, чулуун зэвсгийн зууны эрин, үе шатуудын хугацаа, тооллыг тун ойролцоогоор гаргах өргөн болсмжийг олгодог. Нөгөө талаар хүй нэгдлийн байгууллын үеийн соёл иргэншлийн эд өлгийн дурсгалууд, ялангуяа хүрлийн зууны үеийн олдворууд нь цаг хугацааг гаргах ихээхэн ач холбогдолтой байдаг.

Ойкумены үеэс (нэн эртний хүн бий болсон үеэс) доод палеолит нь ойролцоогоор 100000 жил, дунд палеолит нь 45-40 мянган жил, дээд палеолит 12-10 мянган жил мезолит нь 8 мянган жилээс эрт бус, неолит 3 мянган жилээс эрт бус дууссан гэж үзэж байгаа юм. Харин Хүрэл зэвсгийн үе МЭӨ нэг мянган жилийн эхлэл буюу төмрийн зууны эхлэл хүртэл үргэлжилсэн байна¹⁵.

Ийнхүү харьцангуй тооллыг соёлын үеийг хооронд нь харьцуулах, эсвэл археологийн хэлбэрүүдийг хооронд нь, эсвэл тэдгээрийг байгаль орчин дах өөрчлөлтэй нь харьцуулан гаргадаг билээ. Ялангуяа археологийн эринүүдийг геологийн үе шат, палентологийн эрин /палеозоологийн ба палеоботаникийн/ геологийн эрин үе шатуудтай харьцуулан үзэх нь чухал ач холбогдолтой юм.

Геологийн үечлэл нь дэлхийн давхаргаар тодорхойлогдож, архей, палеозей, мезозой, кайнозой гэсэн дөрвөн томоохон эринд /галавд/ хуваагддаг бөгөөд харин сүүлийнх нь дотроо гурав, дөрөвдөгч үе шатанд хуваагдаж өнөөг хүртэл үргэлжилж байгаа юм. Гуравдагч нь 69 сая жил, дөрөвдөгч нь 1 сая гаруй жил үргэлжилж байгаа билээ. Дөрөвдөгч галавыг плейстоцен

¹³ К.Маркс, Ф.Энгельс. Түүвэр зохиол. III боть, УБ.* 1971. 248 дахь тал

¹⁴ В.П.Алексеев. А.И.Першиц. История первобытного общества. М. 1999. 6-р талд

¹⁵ В.П.Алексеев. А.И.Першиц. История первобытного общества. М.1999. М 6-р талд

/мөстлөгийн өмнөх ба мөстлөгийн үе/, **голоцен** /мөстлөгийн дараах үе/ хоёр томоохон үе шатанд хуваадаг. Археологийн үечлэлээр бол **плейстоцен нь палеолит, мезолитэд, голоцен нь неолитоос** хойших үеүдэд хамаарагдаж байгаа юм.

Археологийн үечлэл нь технологийн шалгуурууд дээр үндэслэснээр шинжлэх ухааны томоохон ололт болсон боловч, нэн эртний нийгмийн үйлдвэрлэх хүчний хөгжлийн төвшинг бүрэн тодорхойлон гаргаж чадаагүй билээ. Харин хөдөлмөрийн багаж зэвсгийн хөгжил, дэвшил, нийгмийн харилцааны хөгжлийн тухай ойлголтыг нилээд тодорхой гаргаж өгсөн билээ. Тиймээс ч археологийн үечлэлийг ихэнх судлаачид зөвшөөрөн хүлээж сургалт судалгаандаа өргөн ашиглаж байгаа юм.

Хүний биологийн хувьсал өөрчлөлтийн шалгуур дээр үндэслэгдсэн **палеоантропологи**н үечлэл нь өөрийнхөө зорилгын хувьд хязгаардмал байдаг. Үүгээр бүр **нэн эртний, эртний, орчин үеийн хүний, өөрөөр хэлбэл архантроп, палеонтроп, неантропын үеүд гэж ялгаж үздэг**. Жинхэнэ хүний системчлэл буюу гоминидын бүлийн эсвэл гоминидын дэд бүлгийн болон тэдгээрийн төрөл зүйлийн нэршлийг судлаачид янз бүрээр нэрлэж иржээ. **Хүний үечлэлд чадварлаг хүн** гэж нэрлэх нь нилээд маргаантай байдаг. Учир нь зарим судлаачид түүнийг хүний өмнөх үеийн хүн гэж үздэг бол зарим нь хүний үе гэж үздэг байна. Хүй нэгдлийн түүхийн үечлэлийн онцгой аспект нь /үзэл нь/ түүнийг **анхны соёл иргэншил бий болохоос өмнө оршин тогтнож байсан хүй нэгдлийн нийгэм, түүнээс хойших соёл иргэншлийн нийгэм** гэж хуваан үздэг.

Ер нь судлаачдын дүгнэж гаргаснаар тэдгээр нь нэг талаас урьдын түүх, нөгөө талаас **прото** /анхны түүх/, **пара** /ойролцоо түүх/, эсвэл **этно** түүх /ард олны түүх/ гэх мэтээр хуваасан бөгөөд үүн дор шинжлэх ухааны салбар төдийгүй түүний судалж буй эринүүдийн ойлголтууд багтдаг¹⁷ гэхдээ энэ нь ерөнхийдөө эх сурвалж, түүний судалгааны ялгаанууд байдаг юм.

Сүүлийн үед хүй нэгдлийн нийгмийн ерөнхий үечлэлийг өрнө дорнын эрдэмтэн, судлаачид нилээд дорвилог судалгаа хийж шинэлэг санал дэвшүүлэн гаргасан юм. **Америкийн эрдэмтэн М.Фрид, Дж.Мэрдок** нар хүй нэгдлийн түүхийг **Эгалитари** /эрх тэгш, хамтач/, **стратифири** /үе давхраажил/, **иерархи** /засаглал, захирагдах ёс/ гэх мэтээр ангилсан нь орчин үед тархаж, судлаачдын анхаарлыг татсаар байгаа билээ. Өөрөөр хэлбэл, **эгалитар** нь хүй нэгдлийн эрин үе, **стратифицир** нь анги үүссэн эрин үетэй тохирч байгаа юм. Харин **эгалитари, стартифицирийн** хооронд **ранжир** /зэрэг дэв/ үе шатыг байрлуулжээ. Үүнээс үзэхэд энэхүү үзэл баримтлалыг дэвшүүлэгчид нь **ранжирогийн үед** зөвхөн нийгмийн тэгш бус байдал, харин **стратифицирийн үед** эд хөрөнгийн ялгаа улам их хүчтэй болж анги, төр үүсч бий болдог байна. Харин иерархи үе шатаны үед захирах захирагдах ёс бий болж, хүн төрөлхтөн, ангит нийгэмд шилжин орсон гэж үздэг байна¹⁸. Энэхүү бүдүүчилсэн таамаглалын **эгалитар** шинж чанар буюу хамтын шинж чанарыг нилээд судлаачид хүлээн зөвшөөрснөөрөө бусдын анхаарлыг татсаар байгаа билээ.

XX зууны үе Оросын болон зарим орнуудын судлаачид **Хүй нэгдлийн нийгмийн түүхийг хүн сүрэг, овгийн байгуулал, задрал буюу цэргийн ардчилал** гэж үечилсэн нь судлаачдын анхаарлыг татаад зогсоогүй нилээд орны сургалт, судалгаанд ашиглаж байгаа юм. Гэхдээ нэн шинэ үеэс хүн төрөлхтний түүхийг, ялангуяа хүй нэгдлийн нийгмийн түүхийг үечлэх оролдлогуудыг хийсээр ирсэн боловч, одоог хүртэл нийтээрээ зөвшөөрөгдсөн нэгдмэл үечлэлийг боловсруулж чадаагүй байгаа билээ. Иймд хүй нэгдлийн нийгмийн түүхийн

¹⁷ В.П.Алексеев.А.И.Першиц. История первобытного общества. М.1999. 8 дахь тал.

¹⁸ Вопросы истории. 1988 №3 81-82 тал

үечлэлийн талаар эрдэмтэн, судлаачдын дэвшүүлсэн санал дүгнэлтийг цогц байдлаар нэгтгэн дүгнэж хүй нэгдлийн нийгмийн түүхийн үечлэлийг цаашид боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байгааг анхаарах зүйтэй болов уу.

х х х х

Дэлхийн аливаа улс үндэстэн бүгд буурал түүхийн урт удаан хөгжлийн явцад бүрэлдэн тогтсоныг түүхийн шинжлэх ухаан нэгэнт магадлан тогтоосон билээ. Орчин үеийн Монголын ард түмний өвөг дээдэс ч мөн л түүхийн тийм хүнд бэрх нарийн ээдрээтэй зам мөрийг туулж өнгөрөөсөн нь тодорхой билээ. Тиймээс монгол нутаг дээр амьдарч байсан нэн эртний хүмүүс түүхэн тэртээ чулуун зэвсгийн зууны үеэс өвөрмөц соёлоо цогцлон бүтээж нийт хүн төрөлхтний соёл иргэншилд хувь нэмрээ оруулсан билээ.

Монголын түүхийн үечлэлийн томоохон нэг үе болох – хүй нэгдлийн нийгмийн байгуулалын түүхийг үечлэхдээ бидний дээр дурьдсан хүй нэгдлийн нийгмийн түүхийн ерөнхий үечлэлийг харгалзан үзэхийн хамт, монголын газар нутгаас олдсон төрөл бүрийн эд өлгийн дурсгалын онцлогоос шалтгаалан цаг хугацааны хувьд ялгаатай байдаг.

Монгол нутагт хүн анх хэдий үеэс эхлэн нутагшин оршин суух болсон, хүй нэгдлийн нийгмийн үе буюу чулуун зэвсгийн эриний хүмүүсийн аж ахуй, эд оюуны соёлын онцлог, тэр нь дэлхийн бусад орны мөн үеийн соёлтой ямар учир холбогдолтой болох, газар тариалан, мал аж ахуйн эх үүсвэр хэдий үед бий болсон зэрэг бичигдмэл түүхийн өмнөх үеийн зангилаа асуудлыг тодруулахад ач холбогдол бүхий нэлээд чухал эд өлгийн дурсгалуудыг сүүлийн жилүүдэд манай нутгаас монголын нэрт эрдэмтэн судлаачид¹⁹ нээж судалсаар байгаа билээ.

Энэ нь монголын түүхийн хүй нэгдлийн нийгмийн байгуулалын үечлэл, түүний үе шат, цаг хугацааны хувьд зарим нэг өөрчлөлт гарч, шинэлэг дүгнэлт хийхэд хүргэжээ. Тухайлбал, монгол нутгаас олдсон палеолитын доод үеийн хамгийн эртний дурсгал нь Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутаг Уранхайрхан уулын орчмын Нарийн голын хөндийгөөс хүний гараар хийгдсэн чулуун зэвсгийн дурсгалууд олдсон нь түүний хамгийн эртнийх нь доод палеолитын үе буюу одоогоос 800000 жилийн тэртээд холбогдож байгаа юм.²⁰

Энэ нь Төв Ази, Монголын говь хээр нутагт манай дэлхийн амьтны аймаг, хүн төрөлхтний нутаг гэсэн өрнө дорнын зарим судлаачдын дэвшүүлсэн таамаглал нэлээд үндэслэлтэй болох нь харагдаж байгаа юм.

¹⁹ Д.Дорж, Д.Цэвээндорж, Б.Гунчинсүрэн, Я.Цэрэндагва.

²⁰ Монголын археологийн судалгаа. 1995.

Abstract:

This publication is aimed at summarizing the viewpoints of numerous scholars on the periodization of ancient societal history, an important era within the history of human civilization; and furthermore, to contribute the author's own ideas and conclusions, thus attempting to systemize this periodization.

Ашигласан ном зүй

1. К.Маркс, Ф.Энгельс. Түүвэр зохиол. III боть УБ, 1971
2. Всемирная история том 1. М. 1955
3. Всемирная история. "Каменный век". В 24 томах. том 1. М. 1996
4. Всемирная история. Учебник для вузов. М. 1997
5. А.Ж.Тойби. Постигание истории. М. 1991
6. История древнего мира. том 1. М. 1979
7. Ю.В.Яковец. Соёл иргэншлийн түүх. УБ. 1999
8. Монгол улсын түүх. УБ., 1997
9. В.П.Алексеев, А.И.Першиц. История первобытного общества. М. 1999
10. А.И.Поршиц, А.Л.Монгайт, Б.П.Алексеев. История первобытного общества. М. 1979
11. Дэлхий дахины түүх. 1 боть. УБ., 2002
12. Монгол улсын түүх. Тэргүүн боть. УБ., 2003
13. Вопросы истории. № 3, 5. 1980 № 7, 8. 1988